



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 11444

Номгон

Иргэний нисэхийн ерөнхий газрын Баянхонгор
аймаг дахь салбарын эзэмшил газрын
зөрчил арилгах тухай

Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалтыг үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Иргэний нисэхийн ерөнхий газрын Баянхонгор аймаг дахь салбарын
(2628546) Зорчигч тээврийн үйлчилгээний зориулалттай газрын талбайн хэмжээ
(103 га) нь зөрүүтэй тул газар дээрх бодит хэмжээ 1044367 м2 талбайгаар залруулж
эзэмшүүлсүгэй

2.Газрын талбайн хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан эзэмшил газрыг
улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн
ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл),
эзэмшил газарт Улсын бүртгэлийн “Э” дугаар олгохыг Улсын бүртгэлийн хэлтэс
(Ц.Мөнхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Эзэмшил газрыг зориулалтын дагуу зүй зохистой ашиглаж цаашид дээрх
зөрчлийг гаргахгүй байхыг Иргэний нисэхийн ерөнхий газрын Баянхонгор аймаг дахь
салбар (Ж.Ганхүлэг)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт,
хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601210033



Аймгийн засаг дарга 2021 оны 07 дугаар сарын
09-ний өдөр 409 дугаар захирамжийн хавсралт

**ЭЗЭМШИЛ ГАЗРЫН ТАЛБAYН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨГДӨЖ
БАЙГАА АЖ АХУЙ НЭГЖИЙН МЭДЭЭЛЭЛ**

Д/д	Газар эзэмшигчийн нэр	регистрийн дугаар	Нэгж талбарын дугаар	Зориулалт	Хаяг	Талбайн хэмжээ /м2/	Залруулгаар нэмэгдэж байгаа талбайн хэмжээ /м2/	Нийт талбайн хэмжээ
1	Иргэний нисэхийн ерөнхий газрын Баянхонгор аймаг дахь салбар	2628546	6409000043	Нисэх буудлын нисэх буух зурвас	Баянхонгор сум, Номгон 1-р баг, Нисэхийн гудамж-4, 409а тоот	1030000 м2	14367 м2	1044367 м2